

switchasia
GRANTS PROGRAMME



Funded by the
European Union



CZECH REPUBLIC
DEVELOPMENT COOPERATION



TU Delft Delft
University of
Technology



МОНГОЛ УЛСЫН БАРИЛГЫН САЛБАРЫН НӨӨЦИЙН ҮР
АШИГТАЙ БАЙДАЛ, ЦЭВЭР ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

СТАНДАРТ, ЖУРМЫН ЭМХЭТГЭЛ



Энэхүү эмхэтгэлийг Каритас Чех Репаблик болон хамтрагч байгууллагуудын хэрэгжүүлж буй “Монгол улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд боловсруулан гаргав. Эмхэтгэлд орсон агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

ГАРЧИГ

1. MNS 6830:2020 Дахин боловсруулалтаас гарган авсан бетонон дайрга. Техникийн шаардлага **04**
2. MNS EN 933-11:2020 Дүүргэгчийн геометр шинж чанарыг тодорхойлох арга 11-р хэсэг: Дахин боловсруулалтаас гарган авсан бетон дайрганы бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох арга **12**
3. MNS EN 1744-6:2020 Дүүргэгчийн химийн шинж чанарыг тодорхойлох арга 6-р хэсэг: Цементийн барьцалдаж эхлэх хугацаанд дахин боловсруулалтаас гарган авсан дүүргэгчийн хандалсан уусмалын үзүүлэх нөлөөг тогтоох арга **13**
4. Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам **14**
5. Стандартын мэдээллийн сувгууд **24**



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ДАХИН БОЛОВСРУУЛАЛТААС ГАРГАН АВСАН БЕТОНОН ДАЙРГА

ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

MNS 6830 : 2020



ЗАХИАЛАГЧ: КАРИТАС ЧЕХ РЕПАБЛИК

Стандарт мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төв.
Худалдан борлуулахыг хориглоно.

2020-06-09

ӨМНӨХ ҮГ

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75%-иас доошгүй дэмжсэн.

СТАНДАРТЫГ БОЛОВСРУУЛСАН ТӨСЛИЙН БАГ:

Төслийн ахлагч Б. Нарантуяа – ШУТИС-ийн Барилга Архитектурын Сургуулийн Хүрээлэн байгаа орчны инженерийн салбар, профессор

С. Цэвэл – ШУТИС-ийн Барилга Архитектурын Сургуулийн Хүрээлэн байгаа орчны инженерийн салбар, профессор

Д. Алтанхуяг – Барилга хөгжлийн төв ТӨҮГ-ын Норм, нормативын хэлтсийн дарга

О. Ариунжаргал – Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Зөвлөх инженер

С. Соронзонболд – Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн, стандартын шинжээч

З. Золзаяа – ШУТИС Олон улсын харилцаа, хамтын ажиллагааны алба хариуцсан ажилтан

Уг стандартыг Барилгын стандартчиллын техникийн хороо (ТХ 22)-ны хурлаар хэлэлцэж дэмжсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)
Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар 13343, Ш/Х-48
Утас 263860, 266754. Факс (976-11) 458032
E-mail: standardinform@masm.gov.mn
Вебсайт: www.estandart.gov.mn

©СХЗГ, 2020

Стандартчилал, техникийн зохицуулал, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 91.100.15

Дахин боловсруулалтаас гарган авсан
бетонон дайрга
Техникийн шаардлага

Recycled aggregate from concrete
waste
Technical requirement



Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн С/11 дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандартыг 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр улсын бүртгэлд бүртгэв.

1. ЗОРИЛГО

Энэхүү стандартын зорилго нь барилга буулгалтын болон үйлдвэрийн бетонон хаягдлаас үйлдвэрлэлийн аргаар буталж гарган авсан $1,2 \text{ г/см}^3$ –ээс багагүй асгаасан нягттай том дүүргэгч материалын техникийн шаардлагыг тогтооход оршино.

2. ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

Энэхүү стандартад заасан дайргыг В22.5 болон түүнээс бага ангийн цуггамал, угсармал бетон, төмөр бетон бүтээгдэхүүний үйлдвэрлэлд том дүүргэгчийн зориулалтаар, мөн замын хажуу хөвөө, хучилтын суурийн доод үе, машины зогсоолын хэсэг, байгаль орчныг нөхөн сэргээх, сайжруулах зориулалтаар ашиглана.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандартад дараах эш татсан стандарт, баримт бичгүүдийг хэрэглэнэ. Он заасан эшлэлийн хувьд эш татсан хэвлэлийг хэрэглэх ба он заагаагүй тохиолдолд тухайн стандартын хамгийн сүүлийн хэвлэл (нэмэлтийн хамт)-ийг хэрэглэнэ. Үүнд:

- **MNS 0390:1998** Барилгын ажилд хэрэглэх дайрга. Ерөнхий техникийн шаардлага;
- **ГОСТ 32495-2013** “Щебень, песок и песчано-щебеночные смеси из дробленого бетона и железобетона. Технические условия”;
- **MNS 5072-2018** “Барилгын материал, хөрс, уулын чулуулагт цацраг идэвхит элемент тодорхойлох гамма спекторын арга”;
- **MNS ГОСТ 8269-1:2016** “Уулын нягт чулуулаг ба үйлдвэрийн хаягдлаас бэлтгэсэн хайрга, дайргыг барилгын ажилд хэрэглэх. Химийн шинжилгээний арга”;

- **MNS 2998-2009** “Барилга замын ажилд хэрэглэх уулын нягт чулуулаг-хайрга, дайрга. Физик механик шинж чанарыг тодорхойлох арга”; EN1744-1:1998 “Tests for chemical properties of aggregates. Chemical analysis”;
- **EN 933-11** “Дахин боловсруулсан дүүргэгчийн бүрдүүлэгчдийг ангилах арга. Дүүргэгчийн геометр шинж чанарыг тодорхойлох арга”;
- **EN 1744-6** “Дахин боловсруулсан дүүргэгчээс хандалсан уусмал цементийнбарьцалдаж эхлэх хугацаанд үзүүлэх нөлөөллийг тогтоох арга”, “Дүүргэгчийн химийншинж чанарыг тодорхойлох аргачлал”.

4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэсэн болно.

4.1 Дахин боловсруулалтаас гарган авсан бетонон дайрга цементэн бетон барилга, байгууламжийн нураалтаас гарсан том хэсгүүд болон бетон үйлдвэрлэлийн гологдол бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар буталж ангилсан том дүүргэгч

4.2 Дахин боловсруулалтаас гарган авсан бетонон дайрганы бохирдолт барилга, байгууламжийн нураалт болон үйлдвэрлэлийн гологдол бетонд агуулагдаж болох тоосго, өнгөлгөөний хавтанцар, асфальт бетон, шаазан эдлэл, шилний хаягдал, гөлтгөнө, шохой, хуванцар болон модон материалуудын хаягдал

5. ДҮҮРГЭГЧИЙН АНГИЛАЛ

5.1 Бетонон дайргыг 1-р хүснэгтэд заасны дагуу чанарын зэрэглэлээр ангилна.

1-р хүснэгт - Дүүргэгчийн чанарын үнэлгээ

#	Ангилал	Нягт, \geq кг/м ³	Ус шингээлт, \leq %
1	1-р зэрэг	2500	3
2	2-р зэрэг	2300	5
3	3-р зэрэг		7

ТАЙЛБАР: 1-сайн чанарын, 2-дундаж чанарын, 3-чанарын доогуур үзүүлэлттэй дайргыг тус тус илтгэнэ. Хатаагуурт тогтмол жинтэй болтол хатаасны дараах дүүргэгчийн нягтыг ангилалд ашиглана.

6. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

6.1 Бетонон дайрга нь гадуураа цементэн зуурмагаар бүрхэгдсэн байдаг учраас байгалийн чулуун материалаас бэлтгэсэн дүүргэгчээс бат бэхээрээ муу, элэгдэлт илүүтэй шинж чанар нь MNS 0390:1998 Барилгын ажилд хэрэглэх дайрга. Ерөнхий техникийн шаардлага– аас ялгаатай болно.

6.2 Бетонон дайргыг шинж чанарын дараах үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

- Ширхэгийн бүрэлдэхүүн;
- Бат бэх;
- Тоосорхог хольц;
- 20 МПа-аас бага бат бэхтэй хэврэг ширхэгийн агуулга;

- Ширхэгийн хэлбэр;
- Хүйтэн тэсвэрлэлт;
- Хөндий хүрдэнд турших үеийн элэгдэлт;
- Хортой хольц;
- Буулгалтаас үүсэх элдэв хог бохирдол;
- Асгаасан үеийн эзлэхүүний нягт.

6.3 Бетонон дайрганы ширхэгийн бүрэлдэхүүнийг MNS 0390:1998 Барилгын ажилд хэрэглэх дайрга. Ерөнхий техникийн шаардлага-д зааснаар тогтооно.

6.4 Бетонон дайргыг цилиндрт шахах үеийн бутрагдалтаар тогтоосон марк нь 2-р хүснэгтэд заасан шаардлагыг хангаж байвал зохино.

2-р хүснэгт - Бутрагдалтын марк

Бутрагдалтын марк	Ус шингээсэн дайрганы туршилтын дараах жингийн хорогдол, %-иар
600	15-20
400	20-28
300	28-30

6.5 Бетонон дайрганд тоосорхог хольц (0,05 мм-ээс жижиг ширхэгтэй) 600 маркад жингийн 2%-иас, 400 маркад жингийн 3%-иас, 300 маркад жингийн 4%-иас тус тус ихгүй байна.

6.6 Бетонон дайрганд 20 МПа-аас бага бат бэхтэй хэврэг ширхэгийн агуулга 300 маркад жингийн 15%-иас, 400 маркад жингийн 10%-иас, 600 маркад жингийн 5%-иас тус тус ихгүй байна.

6.7 Бетонон дайрганд нимгэн үзүүрлэг ширхэгийн хэмжээ жингийн 35%-иас ихгүй байна.

6.8 Бетонон дайрганы хүйтэн тэсвэрлэлтийн марк нь ХТ15-аас ХТ50 хүртэл байна.

6.9 Бетонон дайргыг хөндий хүрдэнд (Los Angeles) туршиж элэгдлийн маркийг 3-р хүснэгтэд заасны дагуу тогтооно.

3-р хүснэгт - Элэгдлийн марк

#	Элэгдэлтийн марк	Жингийн хорогдол, хувиар
1	Э-3	35-45
2	Э-4	45-60

6.10 Бетонон дайрганд хортой хольцын агуулга доорх зааснаас илүүгүй байна. Үүнд:

- Хүхэр, сульфатууд болон сульфидүүд (гөлтгөнө, ангидрид болон бусад)-ийг SO₃-шилжүүлэн тооцсон хэмжээ нь жингийн 1,5%;
- Хлорын ионд шилжүүлэн тооцсон усанд уусдаг хлоридын хэмжээ нь жингийн 0,1%

7. БОХИРДОЛТ

Бетонон дайрганы бохирдолтыг доор дурдсан 2 аргын аль нэгээр тодорхойлж ангилан хэрэглэгчид мэдээлнэ.

7.1 Бетонон дайрганы бохирдолтыг, түүний найрлагад орсон органик бус (керамик, шил, тоосгоны үйрмэл г. м) болон органик гаралтай (хулдаас, мод, рубероид, картон, дулаан тусгаарлах материалууд) хольцын төрлөөр ялгаж тус бүрийн агуулалтын жингийн хувиар (%) 4-р хүснэгтэд заасны дагуу А, Б, В, Г, Д ангилалд хувааж хольцын нийлбэр хувиар (%) тогтооно.

4-р хүснэгт - Бохирдлын зөвшөөрөгдөх хэмжээ

#	Категори	Дүүргэгчид агуулагдах бохирдуулагч хольцын төрөл	Зөвшөөрөгдөх дээд хязгаар, хувиар
1	А	Тоосго, шалны ба өнгөлгөөний хавтанцар, асфальт бетон, шаазан эдлэл	2,0
2	Б	Шилний хаягдал	0,5
3	В	Гөлтгөнө болон шохойн хаягдал	0,1
4	Г	Хуванцар материал	0,5
5	Д	Модон материал	1,0
		НИЙТ	4,1

7.2 Бетонон дайргыг бохирдуулж байгаа органик бус гаралтай (керамик, шил, тоосгоны үйрмэл г. м) болон органик гаралтай хольц (хулдаас, мод, рубероид, картон, дулаан тусгаарлах материалууд)–уудаас нь хамааран дараах дөрвөн бүлэгт хувааж, доорх зориулалтаар хэрэглэнэ.

I бүлэгт, органик болон органик бус хольц агуулаагүй дайрга. Ийм дайргыг В22,5 болон түүнээс бага ангийн бетонд ашиглах боломжтой бөгөөд бутрагдалтын марк нь доорх шаардлагыг хангасан байна. Үүнд:

В15 ба түүнээс бага ангийн бетонд 300–аас багагүй,
В20 ба түүнээс бага ангийн бетонд 400–аас багагүй
В22,5 ба түүнээс бага ангийн бетонд 600–аас багагүй

II бүлэгт, органик болон органик бус гаралтай хольцын агуулга дайрганы жингийн 1% хүртэл байхыг зөвшөөрнө. Ийм дайргыг замын хучилтын суурийн доод үе, нисэх онгоцны хөөрөх буух зурвасын хучилтын доод үе болон индүүдэж нягтруулах бетон хольцын үйлдвэрлэлд ашиглах боломжтой.

III бүлэгт, органик болон органик бус гаралтай хольцын агуулга дайрганы жингийн 1-ээс 3% хүртэл байхыг зөвшөөрнө. Ийм дүүргэгчийг замын хажуу, хөвөө, замын хучилт, машины зогсоолын суурийн доод үенд ашиглах боломжтой.

IV бүлэгт, органик болон органик бус гаралтай хольцын агуулга дайрганы жингийн 3-аас 7% хүртэл байхыг зөвшөөрнө. Ийм дүүргэгчийг байгаль орчныг нөхөн сэргээх, сайжруулахад ашиглах боломжтой.

7.3 Бетонон дайрга нь цацрагийн аюулгүйн байдлаар MNS 5072-2018 “Барилгын материал, уулын чулуулгийн цацраг идэвхт элемент тодорхойлох гамма спекторын арга” стандартын шаардлагыг хангасан байна.

8. БЕТОНД ХЭРЭГЛЭХ ХҮРЭЭ

8.1 Бетонон дайргыг М300 хүртэлх (В22,5) бетоны үйлдвэрлэлд, 5-р хүснэгтэд заасан хэмжээгээр, байгалийн дүүргэгчийг орлуулан хэрэглэнэ.

5-р хүснэгт Байгалийн дүүргэгчийг орлуулан хэрэглэх хязгаар

#	Дайрганы төрөл	Байгалийн дүүргэгчийг орлуулан хэрэглэх боломжит дээд хэмжээ, хувиар
1	1-р зэрэг	30
2	2-р зэрэг	25
3	3-р зэрэг	20

9. ТУРШИХ АРГА

9.1 Бетонон дайрганы физик механик шинж чанарыг MNS 2998:2009 “Барилга замын ажилд хэрэглэх уулын нягт чулуулаг хайрга, дайрга. Физик механик шинж чанарыг тодорхойлох арга”, химийн шинж чанарыг MNS ГОСТ 8269-1: 2016 “Уулын нягт чулуулаг ба үйлдвэрийн хаягдлаас бэлтгэсэн хайрга, дайргыг барилгын ажилд хэрэглэх” химийн шинжилгээний аргын стандартын дагуу туршиж 6-д заагдсан шаардлагад нийцүүлнэ.

9.2 Бетонон дайрганы цементийн барьцалдах хугацааг саатуулах, бетоны бат бэхийг бууруулах зэрэг сөрөг нөлөө үзүүлдэг органик ба бусад хольцын агуулалтыг EN1744-1:1998,15,1 ба 15.2 –ын дагуу тодорхойлно. Хаягдал бетонон дайргыг цэвэр усаар угаахад үүссэн уусмал нь стандарт шингэнээс өөр өнгөтэй байвал цементийн барьцалдаж эхлэх хугацаанд сөрөг нөлөө үзүүлэх хэмжээний органик хольцууд байна гэж үзээд тухайн дайргыг цементэн бетонд хэрэглэхээс татгалзах эсвэл угааж хэрэглэнэ.

Бетонон дайрганы бохирдлыг *MNS EN 933-11 “Дахин боловсруулалтаас гарган авсан дүүргэгчийн бүрдүүлэгчдийг ангилах арга. Дүүргэгчийн геометр шинж чанарыг тодорхойлох аргачлал”*-аар тодорхойлж 7.1-ийн 4-р хүснэгт эсвэл хэрэглээний зориулалтаас хамааруулан 7.2-т заагдсан шаардлагад нийцүүлэх бөгөөд, *MNS 974:2008 “ПОРТЛАНД ЦЕМЕНТ Техникийн шаардлага”* стандартад заасан цементийн барьцалдах хугацаанд тухайн дүүргэгчээс хандалсан уусмалын үзүүлэх нөлөөллийг *MNS EN 1744-6 “Дахин боловсруулалтаас гарган авсан бетонон дүүргэгчээс хандалсан уусмал цементийн барьцалдаж эхлэх хугацаанд үзүүлэх нөлөөллийг тогтоох арга”, “Дүүргэгчийн химийн шинж чанарыг тодорхойлох аргачлал”*-аар тодорхойлох ба нөлөөлөл байгаа нь тогтоогдвол угааж хэрэглэнэ.

10. ХҮЛЭЭН АВАХ, ХАЯГЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ

10.1 Бетонон дайргыг хүлээн авах хаяглах, тээвэрлэх, хадгалах ажиллагааг *MNS 0390:1998 Барилгын ажилд хэрэглэх дайрга-Ерөнхий техникийн шаардлага*-д нийцүүлэн цаг уур (бороо, цас, салхи) гадны хүчний үйлчлэл (нунтагралт, бутлагдалт г.м) бохирдолт (тоос шавар, бусад хольц) ба холигдолт

(ширхэгээр ангилсан хэсгүүдийн холигдолт) гэх мэт бүтээгдэхүүний (цаашид хийх бетон) шинж чанарт мэдэгдэхүйц өөрчлөлт гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн битүү агуулахад хадгална.

10.2 Бетонон дайрганы ус шингээлт өргөн хязгаарт өөрчлөгдөх учир хадгалалтын үед дүүргэгчийн чийг агуулалтыг хүрээлэн буй орчны чийгтэй тэнцүү буюу ойролцоо (тэнцвэрийн чийглэг) байхаар бодож битүү агуулахад ширхэглэл ба зэрэглэлээр тус тусад нь тусгай сав эсвэл тусгаарлах ханатай тасалгаанд хадгалж хаяг шошго байрлуулна.

10.3 Хэрэглэгчид нийлүүлэхдээ тээвэрлэлтийн явцад чийг агуулалт өөрчлөгдөхөөс хамгаалж ус үл нэвтрүүлэх хучлагаар (зориулалтын хучлага) битүү хучна (хучлагад ус нэвчих боломжтой нүх, цоорхой байж болохгүй).

10.4 Хэрэглэгчийн зүгээс дахин боловсруулалтаас гарган авсан бетонон дайргыг тодорхой чийглэгтэй (тэнцвэрийн чийглэгээс илүү) авах хүсэлт гаргавал чийг агуулалтыг бүрдүүлэх ус шүршигч төхөөрөмжөөр агуулахыг тоноглосон байж болно. Гэхдээ чийг агуулалтын нарийвчлал захиалгаас жингийн $\pm 0,1\%$ -ийн хязгаар дотор байх хэрэгтэй.

11 ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН БАТАЛГАА

11.1 Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах, нөхцөлийг хангасан үед дайрганы стандартын шаардлагыг үйлдвэрлэгч хариуцна.

11.2 Удаан хугацаагаар хадгалагдсан дахин боловсруулалтаас гарган авсан бетонон дайргыг чанарын шалгалт хийж хэрэгцээ хангах эсэхийг тогтоосны үндсэн дээр хэрэглэх шаардлагатай.

БАРИЛГЫН ХОГ ХАЯГДАЛД СУУРИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ШИНЖЛЭХ АРГЫН СТАНДАРТУУД БАТЛАГДЛАА

Европын Холбоо, Чехийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Агентлагийн санхүүжилтаар Каритас Чех Репаблик (КЧР) Монгол дахь суурийн төлөөлөгчийн газар нь Монгол улсын Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургууль (ШУТИС), Нидерланд Улсын Дельфтийн Технологийн Их сургууль, (ДТИХ) Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоотой хамтран **“Монгол улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих төсөл”-ийн хүрээнд Барилгын хог хаягдалд суурилсан бүтээгдэхүүний талаарх** стандартуудыг боловсруулсан гаргах ажлыг зохион байгуулсан билээ.

Стандартуудыг барилгын стандартчиллын техникийн хороо (ТХ 22)-ны хурлаар хэлэлцүүлэн, хянуулж, Стандарт, хэмжил зүйн газар /СХЗГ/-аас үндэсний стандартууд батлагдлаа.



“MNS EN 933-11:2020 Дүүргэгчийн геометр шинж чанарыг тодорхойлох арга. 11-р хэсэг: Дахин боловсруулалтаас гарган авсан бетон дайрганы бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох арга” стандарт

Энэхүү Европын стандарт нь дахин боловсруулалтаас гарган авсан бетон дайрганы бүрэлдэхүүн хэсгүүдийн харьцааг тодорхойлох, хэмжээг тооцоолох туршиг аргад хамаарна. Энэхүү стандартаар тогтоосон лавлагаа туршилтын аргыг туршилт хийх болон ямар нэгэн маргаан гарсан тохиолдолд маргааныг шийдвэрлэх зорилгоор ашиглана. Харин бусад тохиолдолд, жишээ нь үйлдвэрлэлийн технологийн хяналтад энэхүү лавлагаа аргатай ижил үр дүн өгөхийг баталсан

тохиолдолд бусад ижил төстэй аргыг ашиглаж болно. Бүтээгдэхүүний хяналт хийхэд ижил төстэй аргыг хослуулан хэрэглэж болно. Уг стандартын агуулгад доорх мэдээллүүдийг багтаасан болно.

1-Р ТАЙЛБАР: Энэ арга нь EN 13055 стандартад дурдсан хөнгөн дүүргэгчид хамаарахгүй.

2-Р ТАЙЛБАР: Энэ аргыг хэрэглэх үед ямар нэгэн аюултай бодис илэрвэл түүнийг тухайн бүс нутагт мөрдөж буй дүрэм журмын дагуу шийдвэрлэнэ.

1. Хамрах хүрээ
2. Норматив эшлэл,
3. Нэр томъёо, тодорхойлолт,
4. Аргын мөн чанар
5. Тоног төхөөрөмж,
6. Туршилтын хэсэгчилсэн дээж бэлтгэх,
7. Туршилтын арга,

8. Үр дүнгийн тооцоолол ба илэрхийлэл,
9. Туршилтын тайлан
10. Нэмэлт мэдээ мэдээлэл

“MNS EN 1744-6:2020 Дүүргэгчийн химийн шинж чанарыг тодорхойлох арга. 6-р хэсэг: Цементийн барьцалдаж эхлэх хугацаанд дахин боловсруулалтаас гарган авсан дүүргэгчийн хандалсан уусмалын үзүүлэх нөлөөг тогтоох шинжилгээний арга” стандарт

Энэхүү стандарт нь цементийн барьцалдаж эхлэх хугацаанд дахин боловсруулалтаас гарган авсан дүүргэгчийн усанд уусдаг бүрэлдэхүүний үзүүлэх нөлөөг тодорхойлох аргыг заасан болно. Уг стандартын агуулгад доорх мэдээллүүдийг багтаасан болно.

ТАЙЛБАР: EN 1744-1:1998 стандартын 15.3 заалтад байгалийн дүүргэгч хэрэглэх үеийн аргыг тусгасан. Энэ нь органик хольцыг илрүүлэх, түүний хэмжээг тодорхойлох арга юм. Харин энэ арга нь органик хольцоос гадна органик бус хольц агуулсан, дахин боловсруулалтаас гарган авсан дүүргэгчийн турших аргад тохирохгүй.

1. Хамрах хүрээ
2. Норматив эшлэл,
3. Нэр томъёо, тодорхойлолт,
4. Урвалж материал
5. Тоног төхөөрөмж,
6. Турших аргын мөн чанар
7. Дээж авах
8. Туршилтын хэсэгчилсэн дээж бэлтгэх,
9. Туршилтын дэс дараалал
10. Үр дүнгийн тооцоолол ба боловсруулалт
11. Туршилтын тайлан

Эдгээр стандартыг дараах бүрэлдэхүүнтэй төслийн баг боловсруулан, үндэсний стандартаар батлуулсан:

Төслийн ахлагч – Б. Нарантуяа, ШУТИС-ийн Барилга Архитектурын Сургуулийн Хүрээлэн байгаа орчны инженерийн салбар, профессор

С. Цэвэл – ШУТИС-ийн Барилга Архитектурын Сургуулийн Хүрээлэн байгаа орчны инженерийн салбар, профессор

Д. Алтанхуяг – Барилга хөгжлийн төв ТӨҮГ-ын Норм, нормативын хэлтсийн дарга

О. Ариунжаргал – Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Зөвлөх инженер

С. Соронзонболд – Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогын газрын ахлах мэргэжилтэн, стандартын шинжээч.

З. Золзаяа – ШУТИС Олон улсын харилцаа, хамтын ажиллагааны алба хариуцсан ажилтан

Стандартын мэдээллийг СХЗГ-ын www.standard.gov.mn веб сайтаас авна уу.



"БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, АНГИЛАХ,
ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ,
УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ"



Захиргааны хэлтэсний
актын улсын нэгдсэн санд
2020 оны 03 сарын 11-ны
өдрийн 48/ дугаарт бүртгээ.

БАРИЛГА, ХОГ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтыг тус, тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Гантулга/-т үүрэг болгосугай.

3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/428 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-ын дагуу бүрдүүлсэн барилгын хог хаягдлын мэдээ, тайланг авч, “Барилгын салбарын нэгдсэн мэдээллийн сан”-д байршуулахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ /Ц.Амарсанаа/-т даалгасугай.


Х.БАДЕЛХАН

151010148

БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ, АНГИЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1.** Энэхүү журам (цаашид “Журам” гэх) нь барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээ, явган хүний зам талбай, ногоон байгууламж шинээр барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, буулгахад үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдлыг цуглуулах, ангилах, цэвэрлэх, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг эрхлэх харилцааг зохицуулна.
- 1.2.** Журмын зорилго нь барилгын хог хаягдлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгалийн нөөц баялгийг хэмнэх, эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино.
- 1.3.** Журам нь Хог хаягдлын тухай хууль, Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн гаргасан баримт бичгүүдээс бүрдэнэ.
- 1.4.** Барилгын хог хаягдлыг үүсгэгч иргэн, хуулийн этгээд, хог хаягдал цуглуулах, ангилах, цэвэрлэх, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “эрх бүхий этгээд” гэх)-ын үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдөнө.
- 1.5.** Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дүгээр тушаалаар батлагдсан Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалтын “аюултай” зэрэглэлд хамрагдсан хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-аар зохицуулна.
- 1.6.** Барилгын хог хаягдлыг үүсгэгч иргэн, хуулийн этгээд нь цуглуулах, ангилах, цэвэрлэх, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаандаа дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
- 1.6.1. Барилгын хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх;
 - 1.6.2. Орон нутгийн онцлог, нөхцөл байдалд тулгуурлан шинэ санаа, шинэ арга, олон улсын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжийг бүрдүүлэх;
 - 1.6.3. Барилгын хог хаягдлыг тус журмын 2.2-т заасны дагуу ангилан ялгах ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй нөхцөлөөр хийж хэрэгжүүлэх;
 - 1.6.4. хог хаягдлын мэргэжлийн ажилтан ажиллуулах;
 - 1.6.5. барилгын аюултай хог хаягдлыг тус журмын 1.5-д заасны дагуу шийдвэрлэх;
 - 1.6.6. барилгын энгийн хог хаягдлыг энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагаар тээвэрлүүлэх, тээврийн зардлыг бүрэн хариуцах.

1.7. Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааг Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т заасан тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгж, байгууллага 26 дугаар зүйлийн 26.1.3-т заасан барилгын ажлын зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэнэ.

1.8. Барилга байгууламжийн буулгалтаас үүсэх хог хаягдлын норматив хэмжээг “Барилгын төсөв зохиох дүрэм” БНБД 81-95-12*/2020/-ийн дагуу тооцно.

1.9. Айл, өрхийн нийтийн болон амины орон сууцны засвараас үүссэн хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/443 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дагуу зохицуулах ба “Барилга доторх хог хаягдлын менежмент-Ашиглалтын дүрэм” MNS BS 5906:2018 стандартыг мөрдлөг болгоно.

1.10. Барилгын хог хаягдлын мэдээллийн санг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/428 дугаартушаалын хавсралтаар баталсан “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-ын дагуу бүрдүүлнэ.

1.11. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа энэ журмын дагуу барилгын хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгсөн эсэхийг харгалзан Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд тусгана.

ХОЁР. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ХАДГАЛАХ

2.1. Барилгын хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлыг ангилах, хадгалах, цуглуулах байршлыг талбайн зохион байгуулалтын зураг төсөлд тодорхой заасан байна.

2.2. Иргэн, аж ахуй нэгж, байгууллага нь үүсгэж буй барилгын хог хаягдлаа эх үүсвэр дээр нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх шинж чанараар тодорхойлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дүгээр тушаалаар батлагдсан Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн “аюултай”, “хяналттай”, “энгийн” зэрэглэлд хамрагдсанаар нь ангилан ялгана.

2.3. “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-тэй ажиллаж, төлөвлөгөөний тайланг ажил дууссанаас хойш нэг сарын дотор аймаг, Нийслэлийн барилгын салбарын төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

2.4. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалтад “хяналттай” болон “энгийн” зэрэглэлд хамрагдсан барилга, барилгын материалын хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах хэрэгцээ, орон нутгийн шаардлагад нийцүүлэн эх үүсвэр, төрлөөр нь ангилан ялгана.

2.4.1. дахин боловсруулах боломжтой барилгын хог хаягдал гэж дараах хог хаягдлыг хэлнэ.

2.4.1.1. Цаас /обой, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, хаягдал цаас/;

2.4.1.2. Хуванцар /төрөл бүрийн гялгар уут, баглаа боодол, бүх төрлийн шингэн материалын сав, сантехникийн шугам хоолой, цахилгааны тоноглол, кабель, хаалга, цонхны хүрээ PVC/;

2.4.1.3. Хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль, тэдгээрээр хийсэн бүх төрлийн материал бүтээгдэхүүн/;

- 2.4.1.4. Шил /бүх төрлийн шилэн сав, хийц, эдлэл, шилэн бүтээгдэхүүн/;
 - 2.4.1.5. Мод, модон эдлэлийн хаягдал;
 - 2.4.1.6. Төрөл бүрийн шуудай, даавуун материалын хаягдал;
 - 2.4.1.7. Дуу дулаан тусгаарлах материалууд, хөөсөнцөрийн хаягдал;
 - 2.4.1.8. Резин, уур, ус, чийгээс хамгаалах бүх төрлийн хуйлмал материалууд;
 - 2.4.1.9. Өвс, мод, чулуу;
 - 2.4.1.10. Бүх төрлийн бетон, төмөр бетон эдлэл;
 - 2.4.1.11. Тоосго, чулуу, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал;
 - 2.4.1.12. Автозамын асфальт бетон, битумын холимог, замын хайрга, шороо;
 - 2.4.1.13. Хаягдал арматур, бүх төрлийн төмөр эдлэл;
 - 2.4.1.14. Бүх төрлийн цахилгаан, холбооны кабелийн утас;
 - 2.4.1.15. Бүх төрлийн сав, баглаа, боодол;
 - 2.4.1.16. Барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо.
- 2.4.2. дахин ашиглах боломжтой барилгын хог хаягдал гэж дараах хог хаягдлыг хэлнэ.
- 2.4.2.1. Суурийн блок;
 - 2.4.2.2. Бүх төрлийн ялуу;
 - 2.4.2.3. Хучилтын хавтан, татанга, төмөр бетон дам нуруу;
 - 2.4.2.4. Тоосго, ханын блок, угсармал барилгын ханын хавтгайлж;
 - 2.4.2.5. Модон эдлэл, эдэлхүүн;
 - 2.4.2.6. Бүх төрлийн сав, баглаа, боодол;
 - 2.4.2.7. Барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо.
- 2.4.3. Устгах, булшлах барилгын хог хаягдал гэж дараах хог хаягдлыг хэлнэ.
- 2.4.3.1. Барилгаас гарсан дахин ашиглах, дахин боловсруулах боломжгүй хаягдал, асбест болон хортой бодис агуулсан, хортой бодисоор бохирдсон, мөнгөн ус агуулсан хаягдлууд;
 - 2.4.3.2. Бохирдсон буюу хортой бодис агуулсан хөрс, шороо, чулуу, нунтаг шороо, бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал, мод, шил, хуванцар.

ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ

3.1. Хог хаягдлыг үүсгэгч иргэн, хуулийн этгээд нь барилга, байгууламж, явган хүний зам талбай, ногоон байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, тоноглох, буулгахад үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, талбайг чөлөөлнө.

3.2. Барилгын иж бүрэн нураалт хийх үед хог хаягдлыг үүсгэгч иргэн, хуулийн этгээд нь “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-тэй ажиллаж тайланг тухайн төсөл дууссанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэлийн барилгын салбарын төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

3.3. Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь Хог хаягдлын тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд нутаг дэвсгэртээ зөвшөөрөлгүй газар асгасан барилгын хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих арга хэмжээг авч ажиллана.

3.4. Зориулалтын бус газарт барилгын хог хаягдлыг хаясан тохиолдолд баг, хорооны Засаг дарга хяналт тавьж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний гаргасан хууль бус үйлдлийг буруутай этгээдийн зардлаар бүрэн цэвэрлүүлнэ.

ДӨРӨВ. ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ

4.1. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын хог хаягдал тээвэрлэх тохиолдолд барилгын хог хаягдал үүссэн байршил бүхий баг, хорооны Засаг даргад мэдэгдэж, сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авч ажиллана.

4.2. Барилгын хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөлтэй этгээд/тээвэрлэгч/холбогдох хууль тогтоомжид нийцсэн тээвэрлэлтийн гэрээг барилгын хог хаягдлыг үүсгэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулж тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

4.3. Хог хаягдал үүсгэгч этгээдтэй гэрээ байгуулсан энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг эрхлэгч эрх бүхий этгээд нь хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх үүрэгтэй.

4.4. Барилгын хог хаягдлыг тээвэрлэхэд тавигдах шаардлага:

4.4.1. “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2011 стандартын шаардлагыг хангаж, техникийн хяналтын үзлэгт хамрагдан, гэрчилгээг авсан байна;

4.4.2. Барилгын хог хаягдал тээвэрлэх машиныг Аймаг, нийслэлийн нэгдсэн GPS-ийн хяналтын системд бүртгүүлсэн байх;

4.4.3. Хог хаягдлыг зориулалтын цэгээс бусад газар хаяхгүй байх;

4.4.4. Тээвэрлэгч нь замын хөдөлгөөнд аюул учруулахгүйгээр соёлтой оролцож, зам дээр хог хаягдлыг асгахгүй байх арга хэмжээ авсан байх;

4.4.5. Барилгын хог хаягдал тээвэрлэх тэвштэй буюу өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл нь хог хаягдлыг гээгдэхээс хамгаалах зориулалтыг хэрэгсэлтэй, өндөрлөгөө, хашлага, бүтээлэгтэй байх;

4.4.6. Машин механизм, тоног төхөөрөмж, өргүүрийн эд ангиуд шаардлага хангасан байх.

4.5. Барилгын хог хаягдал тээвэрлэгч нь тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ, тогтоосон чиглэлийн дагуу тээвэрлэлт хийсэн хуваарь, цаг хугацааны талаарх мэдээ тайланг сар бүрийн 25-ны дотор сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын хог хаягдлын асуудал хариуцсан хэлтэст хүргүүлнэ.

4.6. Барилгын болон газар шорооны ажлын үед гарсан шимт хөрсийг хот тохижуулах байгууллагад тээвэрлэж хүргэнэ.

4.7. Барилгын сууриас гарсан шороог газрын нөхөн сэргээлтэд дүүргэгчээр ашиглахын тулд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн хадгалах талбайд тээвэрлэж хүргэнэ.

ТАВ. ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ

5.1. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгэлтэй, эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж гүйцэтгэнэ.

5.2. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг тухайн аймаг, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр үйлдвэрлэлийн бүсэд олгогдсон газарт барьж байгуулна.

5.3. Дахин боловсруулж шинээр гарган авсан бүтээгдэхүүн, эдлэхүүн, дахин боловсруулалтаас гарсан хог хаягдлын тоо, тайлан мэдээг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

5.4. Дахин боловсруулж гаргаж авсан барилгын материал, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг лабораторийн шинжилгээнд хамруулж, чанар байдалд дүн шинжилгээ хийлгүүлэх, сорьцын дүнг гаргуулан тухайн материал бүтээгдэхүүний холбогдох стандартад нийцүүлсэн байна.

5.5. Дахин боловсруулалтаас үүссэн хог хаягдлыг зөвшөөрөлтэй хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэнэ.

5.6. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч этгээд нь барилгын хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд энэхүү журмын 4.1-ийг баримтална.

5.7. Барилгын хог хаягдлыг хүлээн авах үйл ажиллагаанд тавигдах шаардлага:

5.7.1. Хог хаягдлыг хүлээн авах авто пүүтэй байна;

5.7.2. Диспетчерийн байртай байна;

5.7.3. Хог хаягдлын мэдээллийн санг үүсгэсэн байна;

5.7.4. Зориулалтын авто гаражтай байна;

5.7.5. Тусгай зориулалтын машин, техник, хэрэгсэлтэй байна.

ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ, БУЛШЛАХ

6.1. Барилгаас үүссэн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг /аюултай хог хаягдал хамаарахгүй./ энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт булшилж устгана.

6.2. Тогтоосон байршилд устгах, булшлах үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

6.3. Хог хаягдал устгах, булшлах үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүүжилтийг аймаг, Нийслэлийн төсөвт тусгаж батлуулан ажиллана.

6.4. Барилгын хог хаягдлыг устгах, булшлах зардлыг Хог хаягдлын тухай хуулийн 9.1.4-т заасан энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифаар тооцно

ДОЛОО. ХАРИУЦЛАГА


7.1. Барилгын хог хаягдлыг зөөх, тээвэрлэх үйл ажиллагааг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага зориулалтын бус газарт барилгын хог хаягдлыг хаясан тохиолдолд анхны төлөв байдалд оруулахад шаардагдах зардлыг тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

7.3. Хог хаягдлын тухай хууль зөрчигчдөд Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

7.4. Барилга буулгаж буй хуулийн этгээд “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө” хийгээгүй, тайлан өгөөгүй, хууль бус хог хаягдал үүсгэсэн бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах тухай журам



Каритас Чех Репаблик (КЧР) Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас 2016 оноос хойш хэрэгжүүлж буй “Монгол улсын барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, цэвэр үйлдвэрлэлийг дэмжих” төслийн хүрээнд Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 48 дугаар тушаалаар батлав.

Журмын зорилго: Барилгын хог хаягдлын (БХХ) удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул, эрсдлээс урьдчилан сэргийлэх, байгалийн нөөц баялгийг хэмнэх, эдийн засгийн эргэлтэд оруулахад оршино.

БХХ-д барилга, байгууламж, явган хүний зам талбай, ногоон байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, тоноглох, буулгахад үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг хамруулна.

БХХ-Барилгын хог хаягдал

1

БХХ-ыг үүсгэгч иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлагууд



БХХ-ын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлэх



БХХ-ыг дахин ашиглах боломжийг бүрдүүлэх



Ангилан ялгах ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй нөхцлөөр хийж хэрэгжүүлэх



Хог хаягдлын мэргэжлийн ажилтан ажиллуулах



Барилгын аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”-аар зохицуулна



Барилгын энгийн хог хаягдлыг энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж байгууллагаар тээвэрлүүлэх, тээврийн зардлыг бүрэн хариуцах



БХХ-ын мэдээллийн санг “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-ын дагуу бүрдүүлнэ

2



БХХ-ыг ангилах, хадгалах, цуглуулах байршлыг талбайн зохион байгуулалтын зураг төсөлд тодорхой заах



БХХ-ыг “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу аюултай, хяналттай, энгийн гэсэн зэрэглэлээр ангилан ялгана



“Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-тэй ажиллаж, төлөвлөгөөний тайланг ажил дууссанаас хойш 1 сарын дотор аймаг, Нийслэлийн барилгын салбарын төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ

Дахин боловсруулах боломжтой БХХ

Цаас, хуванцар, шил, мод, модон эдлэл өвс, мод, чулуу, бүх төрлийн сав, баглаа боодол төрөл бүрийн даавуун материал, бүх төрлийн бетон, төмөр бетон, арматур, бүх төрлийн төмөр эдлэл, хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль, дуу, дулаан тусгаарлах материалууд, резин, уур, ус, чийгээс хамгаалах бүх төрлийн хуйлмал материалууд, тоосго, чулуу, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал, автозамын асфальт бетон, битумын холимог, замын хайрга, бүх төрлийн цахилгаан холбооны кабелийн утас, барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо

Дахин ашиглах боломжтой БХХ

Суурийн блок, бүх төрлийн ялуу, хучилтын хавтан, татанга, төмөр бетон дам нуруу, тоосго, ханын блок, угсармал барилгын ханын хавтгайлж, модон эдлэл, эдэлхүүн, бүх төрлийн сав, баглаа боодол, барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо



Устгах, булшлах БХХ

Дахин ашиглах болон боловсруулах боломжгүй хаягдал, асбест болон хортой бодис агуулсан болон хортой бодисоор бохирдсон хаягдлууд

3



Гарсан БХХ-ыг бүрэн цэвэрлэж, талбайг чөлөөлөх



Аймаг, Нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй газар асгасан БХХ-ыг буруутай этгээдийн зардлаар цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих

4

БХХ тээвэрлэгчид тавигдах шаардлагууд



Зөвшөөрөлтэй БХХ тээвэрлэгч нь хууль тогтоомжид нийцсэн тээвэрлэлтийн гэрээг БХХ үүсгэгчтэй байгуулж тээвэрлэлтийг хийнэ



Зөвшөөрөлтэй БХХ тээвэрлэгч нь тээвэрлэж буй БХХ-ыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгөх үүрэгтэй

БХХ-ыг тээвэрлэхдээ баг, хорооны Засаг даргад мэдэгдэж, сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авах



БХХ-ыг зориулалтын цэгт хаях



Аймаг, Нийслэлийн нэгдсэн GPS-ийн хяналтын системд бүртгүүлсэн байх



БХХ тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь өндөрлөгөө, хашлага, бүтээлэг, шаардлага хангасан өргүүрийн эд ангиудтай байх



Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдан, гэрчилгээ авсан байх



Замын хөдөлгөөнд соёлтой оролцож, зам дээр хог хаягдлыг асгахгүй байх

Тээвэрлэсэн БХХ-ын тайланг сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын хог хаягдлын асуудал хариуцсан хэлтэст хүргүүлнэ.

5

БХХ-ыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад тавигдах шаардлагууд



Бүртгэлтэй, эрх бүхий БХХ-ыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага нь гаргаж авсан барилгын материал, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг лабораторийн шинжилгээнд хамруулж, стандартад нийцүүлсэн байна



Дахин боловсруулалтаас үүссэн хог хаягдлыг зөвшөөрөлтэй хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэнэ

БХХ-ыг хүлээн авах үйл ажиллагаанд тавигдах шаардлага

- Хүлээн авах авто пүүтэй байх
- Диспетчерийн байртай байх
- ХХ-ын мэдээллийн санг үүсгэх
- Зориулалтын авто гаражтай байх
- Тусгай зориулалтын машин, техник, хэрэгсэлтэй байх

- Аймаг, Нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулсан ААН нь дахин боловсруулах боломжгүй энгийн БХХ-ыг төвлөрсөн цэгт булшилж устгана. (Аюултай ХХ хамаарахгүй)
- БХХ-ыг устгах, булшлах зардлыг энгийн хог хаягдлыг булшлах зардлын тарифаар тооцно.
- Зориулалтын бус газарт хог хаясан хуулийн этгээд тухайн газрыг анхны төлөв байдалд нь өөрийн зардлаар оруулах хариуцлага хүлээнэ.
- Хог хаягдлын тухай хууль зөрчигчдөд Зөрчлийн тухай хуулийн 6.1. дүгээр зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

1800-2525 дугаарт ТА дараах асуудлаар хандах боломжтой



Санал



Гомдол



Хүсэлт



Мэдээлэл

Мэдээллийн суваг



Стандарт, хэмжил
зүйн газар



www.masm.gov.mn



Стандарт, хэмжил
зүйн газар



www.estandart.gov.mn



1800-2525
хэрэглэгчийн утас



20 аймгийн
салбар хэлтэс

Стандартын мэдээлэл, лавлагаа,
сургалтын үндэсний төв

standardinform@masm.gov.mn

Утас: 51-263860



2020оH